

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМГИЙН 2019 ОНЫ ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, АВТО ЗАМЫН САНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БУА-/2020/04-ГА

Орон нутгийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн хөрөнгөөр нийт 54 төсөл арга хэмжээ хэрэгжсэн байна.

БУЛГАН АЙМАГ 2020 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn
Аудитын менежер Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Аудитор Б.Энхтөр
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	1
Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй	2

БҮЛЭГ А. ОНХО-т, авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан эсэх

А.1. ОНХО-т, авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулжээ.	5
А.2 Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ салбарын бодлого, ТЭЗ-ын саналд үндэслэж төлөвлөсөн байна.	7
А.3 Төсөл арга хэмжээний зураг төсвийг үндэслэлтэй боловсруулсан байна.	8
А.4 Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой хугацаанд нь 16 сум, 1 тосгонд эрх шилжүүлсэн байна.	8

БҮЛЭГ Б. ОНХО-т, авто замын сангийн төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Б.1. Нэг төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль журмын дагуу зохион байгуулагдаагүй байна.	8
Б.2. Гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.	9
Б.3. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд зарцуулагдах төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.	10
Б.4 Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгосон байна.	11

БҮЛЭГ В. Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх

В.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар ажлын үр нөлөөг тооцож ажилласан байна.	11
В.2. Хөрөнгө оруулалтын ажилд дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллажээ.	11
В.3 Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.	11

ДҮГНЭЛТ	11
---------	----

ОИХЭЭНИЙ ТЭНГЭЛ ААНЛАЭӨ

ОАИАОАА-ОАОО	Оооооо аааааа ии иоооооо и-оооооо оооооооо аааааа аааааа зээ-эээүү оооооооооо аааааа оооооо оооооо
ОАИАОО	Оооооо аааааа ии иоооооо и-оооооо оооооо оооооо
ТТХ	Төсвийн тухай хууль
БТХ	Барилгын тухай хууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОООИ	Оооооо оооооооо оооооооо иооооооо
УАГ	Үндэсний Аудитын газар
ЧАОҮА	Чааааааа аааааааа оооооооо оооооооо аааааа
ЭОО	Эооооооо оооооооооо-аааааа оооооо
АЗД	Аймгийн Засаг дарга
ЧАОА	Чааааа аааааааа оооооооо аааааа
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТАЗГ	Тээвэр авто замын газар
АОАОАА	Аааааааа оооооооооо аааааааа оооооо ааааааоооооооо аааааа
О ^а ОЕ	Оооооооо и-оооооо оооооооооооо оооооооо
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ООЕ	Оооооооооооооооо оооооооооооооооо оооооооо

2019.03.25

Áóëãàí

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Монгол Улсын Ерөнхий аудиторовн “Аудитын сэдэв батлах” 2019 оны А/100 дугаар тушаалаар Булган аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15.1.5 дахь заалтын дагуу бүрэн эрхийн хүрээнд аудит хийнэ. Аймгийн төсөв, сангийн 2019 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнгүй аудит хийж, аудитын үр дүн, дүгнэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ.

Аудитын зорилт

- Орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилт төлөвлөгөөний дагуу хийгдсэн эсэх
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон авто замын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнтэй эсэх
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын үр дүн, үр нөлөөг тооцсон эсэх
-

**Аудитын хамарсан
хүрээ**

Булган аймгийн хэмжээнд орон нутгийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн 2019 онд санхүүжүүлсэн төсөл арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хамрууллаа.

**Аудитын
хязгаарлалт**

.....

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**


Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/, гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүй нь аудитын бүх үе шатны туршид үргэлжлэх үйл ажиллагааг хамрах тул гүйцэтгэл, тайлагналын үе шатанд нэмэлт горим хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд өөрчлөлт оруулж болно. Шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан төсөвт байгууллага ажлын хэсгийн ажилтнуудаас асуулга авах, ХАА-ны төлөвлөгөө, тайлан, захиалагч, гүйцэтгэгч, санхүүгийн тайлан, бусад шаардагтай баримт материал судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг аймгийн төрийн аудитын газрын даргын удирдамжаар аймгийн Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр удирдаж, менежер Ж.Энхцоодол хяналт тавьж ахлах аудитор П.Мөнхтуяа, аудитор Б.Энхтөр нар 2020 оны 04 дугаар сарын 23-ний өдрөөс эхлэн ажлын 35 хоногт багтаан хийж гүйцэтгэнэ.
Хүндрэл бэрхшээл	Аудит хийх ажлын хоног боломжийн боловч санхүүгийн аудиттай дуусаагүй байсан тул зарим үед ажлын ачаалал их байлаа.
Эрсдэлийн үнэлгээ	Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн аудитын төлөвлөлтийн явцад ирүүлсэн судалгааны баримт материал, түүнд тулгуурлан хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн аудитын ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үзлээ.
Àóäèòäà àøèäèñàí øäèäóóð ¿ç¿¿ëýèð¿ä	• Монгол улсын төсвийн тухай хууль • Барилгын тухай хууль • Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль • Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль • Орон нутгийн авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам • Гэрээний биелэлтийг тооцох • Холбогдох бусад хууль, тогтоомж

А.1. ОНХО-т, авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг хууль, журмын дагуу төлөвлөж батлуулсан байна.

Булган аймагт 2019 онд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1404.9 сая төгрөгийн 41 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан байна. Тус тогтоолын 2-р хавсралтаар аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр 38 төсөл, арга хэмжээг 1213.5, 3-р хавсралтаар авто замын сангийн хөрөнгөөр 5 төсөл, арга хэмжээг 312.0 сая төгрөгөөр тус тус хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулжээ. Мөн 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн аймгийн ИТХ-аар батлагдсан төсөвт өөрчлөлт оруулж дулааны станцын цахилгаан ханамжийг аваарын нөөц эх үүсвэртэй болгох, Бугат сумын Иргэний танхимын засвар, тохижилт, Нэгдсэн эмнэлгийн моорогийн барилга зэрэг төсөл, арга хэмжээг нэмж тусгасан байна.

ОНХО, авто замын сангийн төсөл арга хэмжээг графикаар харуулбал:



ОНХО-аар хийгдэх төсөл арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Тоо ширхэг	Батлагдсан дүн /сая.төг/
1	Засаг даргын тамгын газрын суудлын автомашин шинэчлэх	4	200.0
2	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих, 75 хүүхэд /Сэлэнгэ сум/	1	303.5
3	Эрүүл мэндийн төвийн барилгын засвар /Могод сум/	1	250.0
4	Сургуулийн барилгын засвар /Баяннуур сум/	1	150.0
5	Засаг даргын тамгын газрын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх	17	170.0
6	Сумын эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж	14	140.0
	ДҮН	38	1213.5

Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Батлагдсан дүн /сая.төг/
1	Орон нутгийн чанартай авто замын засвар, арчлалт	175.0
2	Байгалийн гамшгийн үеийн авто зам, замын байгууламжийн засвар	50.0
3	Булган сумын авто замын засвар	42.0
4	Зам, тээврийн хяналтын төвийн зардал	15.0
5	Шинээр хийлгэх зураг төсвийн зардал гэх мэт орон нутгийн шаардлага хангасан бүтээн байгуулалтын хийгдэхээр төлөвлөсөн байна.	30.0
	ДҮН	312.0

А.2 Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ салбарын бодлого, ТЕЗ-ын саналд үндэслэж төлөвлөсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн саналыг харгалзан үзэж хэрэгцээ шаардлагад нийцсэн орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих 38, авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх 5 саналыг дэмжиж ажиллажээ.

Боловсролын салбарын байгууллагуудын барилгын өргөтгөл барих, их засвар хийх ажлыг Баяннуур сумын сургуулийн барилгын засвар, Сэлэнгэ сумын 75 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих мөн Дашинчилэн, Бүрэгхангай, Орхон, Хангал сумдын ЗДТГ-ын суудлын авто машин, 16 сум 1 тосгоны ЗДТГ-ын компьютер, техник хэрэгслийг шинэчлэх, 13 сум 1 тосгоны Эрүүл мэндийн байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулан, мэдээллийн технологийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах зэргээр явуулын ехоны тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж ажиллажээ.

Орон нутагт хийгдсэн эдгээр төсөл, арга хэмжээ нь салбарын бодлогын хүрээнд шаардлагатай байсан бөгөөд үр дүнтэй, хэрэгцээ шаардлагад нийцсэн ажил болжээ.

Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр Баяннуур - Дашинчилэн сумын чиглэлд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн газраас замын тэмдэг тэмдэглэгээ, самбар байршуулах, Зоон даваа хяналтын постын гэрэл цахилгааны зардал, Булган сумын 4-р баг /Зүүн түрүү/-т 1.8 км хатуу хучилттай авто замын зураг төсвийн хяналт, Сэлэнгэ сумын 21 км авто замын засварын шатахууны зардал, Булган сумын хатуу хучилттай авто зам засвар арчлалт, Орхон сумын төвийн авто зам засвар, Рашаант сумын Тарнын гүүрний замын байгууламж, Хутаг-

Өндөр сум Цуурайн давааны зам засвар, Хангал сум 1-р баг Гурван эвэртэйн авто замын засвар, Сэлэнгэ сумын Шаврын голын гүүр болон 437.02м төмөр бетон гүүрний хоорондох авто зам засвар, Тэшиг сумын Хужирт багийн 3.4км авто замын байгууламжийн засвар арчилгаа, Зоон давааны хяналтын постын засвар, Булган сумын 1-р баг Шинэ хорооны авто зам засвар, Булган сумын 6-р баг, Залуус хотхоны авто замын байгууламжийн зураг төсөв боловсруулахад шаардлагатай инженер геологийн судалгааны ажил нийт 252.6 сая төгрөгийн санхүүжилтээр тус тус гүйцэтгэсэн байна.

А.3 Төсөл арга хэмжээний зураг төсвийг үндэслэлтэй боловсруулсан байна.

"Булган сумын 6-р багийн нутаг, Залуус хороолол чиглэлийн хатуу хучилттай авто болон явган зам, түүний орц гарц, авто машины зогсоолын талбай, тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлэг шинээр байгуулах" ажлын зураг төсөв боловсруулах ажил Булган аймгийн Засаг даргын №АЗС/01/2018 ажлын даалгавраар хийгдэхээр сонгон шалгаруулалтыг 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/498 дугаар захирамжаар үнэлгээний хороо байгуулж Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 ¹ тендер зарлаж "Ихэр Мөнх" ХХК-тай 2019 оны 12 дугаар сарын 19-ны өдөр гэрээ байгуулах боломжтой болсон мэдэгдэл хүргүүлсэн гэрээ байгуулсан байна.

А.4 Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой хугацаанд нь 16 сум, 1 тосгонд эрх шилжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн санхүүжилтээр 4 сумын авто машиныг шинэчлэх 200.0, 16 сум, 1 тосгоны компьютер, техник хэрэгслийг шинэчлэхэд 170.0 сая төгрөгийн эрхийг шилжүүлж хийж гүйцэтгэсэн байна.

Бүлэг Б: ОНХО-т, авто замын сангийн төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна.

Б.1. Нэг төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль журмын дагуу зохион байгуулагдаагүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн авто машин, сургууль цэцэрлэгийн өргөтгөл, засвар, ЭМТ-ийн тоног төхөөрөмж, засвар, сумын ЗДТГ-ын компьютер техник хэрэгсэл, хатуу хучилттай зам талбайн засвар арчлалт зэрэг худалдан авах ажлыг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан боловч Сэлэнгэ сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилга шинээр барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн

¹ Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйл.Худалдан авах ажиллагааны журмын 7.1-д Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна 7.1.1.нээлттэй тендер шалгаруулалтын журам, 7.2.Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө.

28 дугаар зүйлийн 28.7.4² дэх гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй тул тендерт оролцогчид Сангийн яаманд гомдол гаргаж шаардлага хангасан хамгийн бага үнийн санал болгосон компанийг дахин үнэлгээний хороогоор сонгон шалгаруулсан байна. Хангал сумын ЗДТГ-ын суудлын автомашиныг шинэчлэхэд ОНХО-аар 50.0, тоног төхөөрөмжийн данснаас 10.0, нийт 60.0 сая төгрөгийн тендер зарласан байна. Бүрэгхангай сумын ЗДТГ-ын автомашиныг шинэчлэхэд Засаг даргад хүргүүлсэн зөвлөмжийг хүчингүй болсон хуулийн заалтаар зөвлөсөн, Орхон сумын ЗДТГ-ын автомашиныг шинэчлэхэд ОНХО-аас 50.0, нэмэлт санхүүжилтийн данснаас 10.0 сая төгрөгийг гаргасан байна³.

Б.2. Гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 38, авто замын сангийн хөрөнгөөр 5 төсөл арга хэмжээ, төсөв өөрчлөлт оруулах тухай №13/1 тоот тогтоолын хавсралт 2 дахь хавсралтаар 3 төсөл арга хэмжээг хугацаа хэтрүүлэлгүй гүйцэтгэж ажил хүлээж авах комисст хүлээлгэн өгсөн бол Дулааны станцын цахилгаан хангамжийг аваарын нөөц эх үүсвэртэй болгох ажлын гэрээ 2019 оны 10 дугаар сарын 25-аас 2019 оны 12 дугаар сарын 25-ыг хүртэлх 60 хоногийн хугацаатай байсан бол цаг агаар, улирлаас шалтгаалж 2020 оны 05 дугаар сарын 20-н хүртэлх хугацаагаар сунгасан байна.

Сумын ЗДТГ-ын компьютер, техник хэрэгслийн шинэчлэлтийг хүснэгтээр харуулбал:

№	Сум	Гүйцэтгэгч компани	Санхүүжилт
1	Баян-Агт	"Гурван уулын хишиг" ХХК	10.0
2	Баяннуур	"Би си ти" ХХК	9.8
3	Бугат	"Ди эн эйч сервес" ХХК-4.0 сая, "Нано шоп" ХХК-6.0 сая	10.0
4	Булган	Ди эн эйч сервес ХХК	9.9
5	Бүрэгхангай	"Өрнөх хийморь" ХХК	10.0
6	Гурванбулаг	"Бэрхийн толь" ХХК	10.0
7	Дашинчилэн	"Фэйд трий" ХХК	10.0
8	Могод	"Про ай ти" ХХК	10.0
9	Орхон	"Өрнөх хийморь" ХХК	10.0
10	Рашаант	"Би си ти" ХХК	10.0
11	Сайхан	"ЮЮУ" ХХК	10.0
12	Сэлэнгэ	Ш.Гомбожав	10.0

² "Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг <хамгийн сайн> тендер гэж үзнэ"

³ Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааны зарчмын 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална"

24 дүгээр зүйл. Тендер ирүүлэх болон хүчинтэй байх хугацаа 24.1-п "Захиалагч тендерт оролцогчдод тендер бэлтгэж ирүүлэх хангалттай, ижил хугацаа олгоно" 24.2-д "Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацааг тендер шалгаруулалтыг анх зарлан мэдээлсэн өдрөөс эхлэн тооцож тогтооно" 24.3-д "Нээлттэй тендер шалгаруулалтын тухайд тендер хүлээн авах эцсийн хугацааг 30 буюу түүнээс дээш хоногоор тогтооно" 24.5-д "Тендер нээснээс хойш тухайн тендер шалгаруулалтыг 45 хоногт багтаан зохион байгуулж дуусгах бөгөөд уг хугацаанд тендер хүчинтэй байна"

Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.3-т "тендер нь энэ хуулийн 27.1-т заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ" заалт 28.7.4-д "хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер гэж үзнэ"

13	Тэшиг	"Ди эн эйч сервес" ХХК	9.9
14	Хангал	"Би си ти" ХХК	9.9
15	Хишиг-Өндөр	"БСБ коммерс" ХХК	10.0
16	Хутаг-Өндөр	"Сунт хөгжил" ХХК	10.0
17	Хялганат	"Саммит компьютер" ХХК	10.0

Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн ажил

■ Авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн ажил



Б.3. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд зарцуулагдах төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар ажил үйлчилгээ, худалдан авалт хийх төсөвт өртөг нь 1800.8, үүнээс 2019 онд санхүүжих 1213.5 сая төгрөгийг зарцуулахаар батлуулсан байна. Авто замын сангийн хөрөнгөөр 312.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээ гүйцэтгэхээр батлуулснаас 13 ажил хийгдэж 252.6, ОНХО-аар 38 төсөл арга хэмжээнд 1204.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

2019 оны тодотголоор дулааны станцын цахилгаан хангамжийн аваарын нөөц эх үүсвэртэй болгох, Бугат сумын Иргэний танхимын засвар, тохижилт, Нэгдсэн эмнэлгийн моорогийн барилын засварын ажил тодотголд орж нийт 195.1 сая төгрөг тусгагдсанаас гүйцэтгэлээр 191.4 сая төгрөг буюу 3.7 сая төгрөг хэмнэсэн байна.

ОНХО-аар хийгдсэн төсөл арга хэмжээнээс 7.6 сая төгрөг хэмнэгдэж орон нутгийн дансанд төвлөрүүлж, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнээс 59.4 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна.

Булган аймгийн Засаг даргын 2016-2020 оны "Хөгжлийн хөтөч" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төлөвлөгөө, Төрийн болон орон нутгийн төсвийн

хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, төсвийн тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Б.4 Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь бүрэн олгосон байна.

2019 онд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 41 ажил төсөл арга хэмжээ хэрэгжиж нийт 1396.3 сая төгрөгийн санхүүжилтийг тухайн гүйцэтгэгч аж ахуй нэгжийн дансанд хуваарийн дагуу шилжүүлсэн байна.

Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээ нийт 252.6 сая төгрөг зарцуулснаас зам, тээврийн хяналтын төвийн зардал 8.1, зам ашигласны хураамж 7.5, төсөл арга хэмжээ 236.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Бүлэг В: Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

В.1 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар ажлын үр нөлөөг тооцож ажилласан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл арга хэмжээ, авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн зам талбайн засвар үйлчилгээг сонгон шалгаруулалтаар шалгарсан аж ахуй нэгж гэрээнийхээ хугацаанд чанартай гүйцэтгэж хүлээлгэн өгч ажиллажээ.

В.2 Хөрөнгө оруулалтын ажилд дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллажээ.

Орон нутгийн хөрөнгөөр хийгдсэн техник хэрэгсэл, суудлын авто машиныг шинэчлэх, сумын ЭМТ-дэд эрүүл мэндийн мобайл тоног төхөөрөмж, сумын Эрүүл мэндийн төв болон сургууль, цэцэрлэгийн өргөтгөл, барилгын засвар үйлчилгээ, авто замын сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээг дотоод хяналтаар үр дүнтэй гэж үзсэн байна.

В.3 Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.

Өмнөх оны Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын зөрчил болон зөвлөмжийн хариу бүрэн биелсэн байна.

ДҮГНЭЛТ:

- Орон нутгийн хөрөнгө оруулалт, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 54 төсөл арга хэмжээнээс 51 төсөл арга хэмжээ нь хууль журмын дагуу хийж гүйцэтгэсэн байна.
- Сэлэнгэ сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилга шинээр барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулагдаагүй байна.
- Хангал сумын ЗДТГ-ын суудлын автомашиныг шинэчлэхэд ОНХО-аар 50.0, тоног төхөөрөмжийн данснаас 10.0, Орхон сумын ЗДТГ-ын автомашиныг шинэчлэхэд ОНХО-аас 50.0, нэмэлт санхүүжилтийн данснаас 10.0 сая төгрөгийг гаргасан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аймгийн Засаг дарга З.Батзоригт

1. Төсөл арга хэмжээнд хяналт тавьж ажиллах, ажлын хэсэг болон комиссын гишүүдийн хяналтыг сайжруулж ажиллах
2. Авто машин худалдан авах ажлыг батлагдсан төсөвт багтаан гүйцэтгүүлж байх.

Аймгийн ОНӨГ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анхбаярт

1. Худалдан авах ажиллагааны комиссын сонгон шалгаруулах Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4⁴ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах
2. Сангийн сайдын 2018 оны 58 дугаар тушаалаар батлагдсан Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлалын дагуу дотоодын эрхийн зөрүүг тооцож байх.

МЭДЭГДЭЛ:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулж хэрэгжилт, үр дүнг 2020 оны 09 дүгээр сарын 15 -ны өдрийн дотор хариу ирүүлэхийг мэдэгдье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
МЕНЕЖЕР

Д.АНХБАЯР
Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР

Б.ЭНХТӨР

⁴ хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер гэж үзнэ.